

## **БЗСЯам (Боловсрол, залуучууд, спортын яам)**

### **СУРГУУЛИЙН ӨМНӨХ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН АРВАН ЗҮЙЛС**

#### **1. Хүүхэд бие бялдар ба хөдөлгөөний хувьд хангалттай төлөвшсөн, бие махбодоо ухамсартайгаар удирдаж, бие дааж өөртөө үйлчилдэг байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- чиглэлийн баримжаатай хөдөлдөг, боломжийн авхаалжтай, чадварлаг (жишээ нь: бөмбөг шидэж, барьж авах, нэг хөл дээрээ тэнцвэрээ хадгалах, гүйх, үсрэх, хэвийн орчинд аюулгүй хөдөлдөг)
- хувцасныхаа цахилгааныг татах ба тайлах, жижиг товчийг тайлах, үдээсээ үдэх, малгай ба бээлийгээ өмсөх)
- хооллохдоо бие даасан байдаг (халбага, сэрээ, хутга зөв хэрэглэдэг, ундаа хийж авдаг, цэвэрхэн хооллодог, салфетка хэрэглэдэг)
- хувийн ариун цэврээ бие даан хийж чаддаг (нусны алчуур хэрэглэдэг, нусаа нийж чаддаг, гараа угааж, хатаадаг, ариун цэврийн цаас хэрэглэдэг, 00-ийн усыг татдаг, хэрэглэсэн зүйлсээ цэгцэлж тавьдаг)
- бага зэргийн цэвэрлэгээний ажлыг хийдэг (эд зүйлсийг, хэрэгслүүдийг зориулалтын газарт нь хурааж цэгцлэх, бэлтгэж тавих, тоглоомоо хураадаг)
- эд зүйлдээ арчилдаг (тэдгээрийг эмх цэгцтэй байлгадаг).

#### **2. Хүүхэд сэтгэл хөдлөлийн хувьд харьцангуй бие даасан, өөрийнхөө зан төлөвийг хянах, удирдах чадвартай байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- эцэг эхийгээ дагахгүй үлдэж чаддаг
- бие дааж ярьдаг, өөрийн санал бодолтой байдаг, санал нийлэх болон нийлэхгүй байгаагаа илэрхийлдэг
- сэтгэл санааны хувьд тогтвортой, сэтгэл санааны байдал нь мэдэгдэхүйц өөрчлөгддөггүй
- биеэ барьдаг ба хянадаг (бага зэргийн амжилтгүй байдалд зохицсон хариу үйлдэл үзүүлдэг, хүслээ хойш нь тавьж хойшлуулж чаддаг, тодорхой үйл ажиллагаа эсвэл нөхцөл байдалд дасан зохицож чаддаг)
- өөрийн зан үйлдлийн хариуцлагыг ухамсарладаг
- тохиролцсон журмыг баримталдаг.

#### **3. Хүүхэд боломжийн хэл, яриа ба харилцааны чадвартай байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- бүх авиаг зөв дууддаг (чичиргээ, эргэлт, зөөлрүүлэхийг бас)

- өгүүлбэрээр ярих, болсон үйл явдлыг хүүрнэх, нөхцөл байдлыг дүрслэж хэлэх г.м.
- голдуу дүрмийн хувьд зөв ярьдаг (энэ нь хүйс, тоо, цаг, хэлбэр, үг, угтвар ба дагавар үгийг г.м-ийг зөв хэрэглэдэг)
- өөрийнх нь орчинд түгээмэл хэрэглэгддэг ихэнх үг ба хэллэгийг ойлгодог
- зохих үгсийн сантай, эргэн тойрныхоо ихэнх зүйлсийг нэрлэж чаддаг
- хүүхэд ба насанд хүрэгчидтэй жирийн бөгөөд ойлгомжтой ярьж, харилцан яриа өрнүүлдэг, түүний дүрмийг хүндэтгэдэг
- нэрээ дармал үсгээр бичихийг оролддог (зурсан зургаа тэмдэг эсвэл үсгээр тэмдэглэнэ)
- байгалийн яриан бус харилцааг (дохио, нүүрний хувирал, биеийн хөдлөл г. м.) ашигладаг.
- багаар хамтран ажилладаг.

#### **4. Хүүхэд гар ба нүдний хөдөлгөөн, нарийн үйлдэл, баруун ба зүүн чиглэлийн чадварыг эзэмшсэн байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- өдөр тутмын хэрэгцээний зүйлс, тоглоом, туслах зүйлс ба багаж хэрэгсэлтэй чадварлаг ажиллах угсрах тоглоом, загвар эвлүүлэх, зүсэх, зурах, будах, цаас нугалах, салгах, наах, номны хүүдсыг зөв эргүүлэх г.мэт.)
- жижиг зүйлстэй (шүрэн бөмбөлөг, барилгын жижиг элементүүд г. м.) ажиллаж чаддаг.
- харандааг зөв барьдаг, энэ нь хоёр хуруугараа барьж гуравдахиар нь дэмжиж тулсан, гарын бугуй сул байх
- харандаагаа салгахгүй зурдаг, зурсан зураас нь жигд байна (тойруулж зурах, будах, зурганд дэлгэрэнгүй мэдээлэл, хөдөлгөөний илэрхийлэл нэмэгдэх)
- геометрийн үндсэн дүрс (дөрвөлжин, тойрог, гурвалжин, тэгш өнцөгт), янз бүрийн хэлбэр (үсэг ч байж болно) дуурайлгаж чаддаг.
- баруун ба зүүн тал, баруун ба зүүн гараа ялгадаг (алдаа байж болно)
- эд зүйлсийг ихэвчлэн зүүнээс баруун тийш байрлуулдаг
- зураг зурах юмуу өөр үйлдэл хийхдээ баруун эсвэл зүүн гараа давуу ашигладаг (хүүхэд баруун эсвэл солгой эсэх нь ихэвчлэн тодорхой байдаг).

#### **5. Хүүхэд харааны болон сонсголын мэдрэмжийн ялгах чадвартай байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- эд зүйлсийн үндсэн шинж тэмдэг ба чанарыг (өнгө, хэмжээ, хэлбэр, материал, дүрс ба дэвсгэр) ялгах ба харьцуулж, тэдгээрийн нийтлэг ба ялгаатай шинж чанарыг олж хардаг.
- хэд хэдэн сонссон үеээс үг, хэд хэдэн дүрсээс зураг эвлүүлж зохиодог
- дуу авиаг ялгадаг (нийтлэг зүйл ба акустик нөхцөл байдал, түүнчлэн энгийн хөгжмийн зэмсгийн дуу чимээ)
- дуу авианы ялгааг таних (зөөлөн ба хатуу, богино ба урт)
- үгийг сонсголоор үеүүдэд хуваах (үгэнд байгаа үеийг алга таших)

- хоёр зургийн ялгааг олж, жижиг мэдээллийг гүйцээж бөглөнө
- энгийн зурган тэмдэг ба тэмдэглэгээг, хийсвэр хэлбэртэй энгийн тэмдэг ба тэмдэглэгээнүүдийг (үсэг, тоо, замын үндсэн тэмдэг, дүрсэн тэмдэглэгээ) ялгадаг.
- ойр орчныхоо болон зурган дээрх өөрчлөлтийг (шинээр юу нэмэгдсэн, юу дутагдаж байгааг) анзаардаг
- гэрлэн болон дуут дохионд зөв хариу үйлдэл үзүүлдэг.

## **6. Хүүхэд энгийн логик ба сэтгэхүйн үйлдлүүдийг эзэмшиж, математикийн анхан шатны ойлголтуудыг мэддэг байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- тооны тухай ойлголттой (хуруу эсвэл эд зүйл дээрх тоог харуулдаг, хуруугаараа тоолдог, нэг нэгээр тоолж чаддаг, тоо нь юмны тоо ширхэгийг илэрхийлдэг гэдгийг ойлгодог)
- энгийн тооны ойлголттой (тоог дарааллаар нь цувуулж, багадаа тав (арав) хүртэлх зүйлсийг) тоолдог.
- хоёр жижиг багцын тоог, өөрөөр хэлбэл тав хүртэлх зүйлсийн тоог харьцуулдаг (ялгааг таньж, нэг нь нөгөөгөөсөө хэдээр их эсвэл бага болохыг олж тогтоох)
- геометрийн үндсэн хэлбэхүүдийг (тойрог, дөрвөлжин, гурвалжин г.м.) таньдаг
- эд зүйлсийн шинж чанарыг ялгадаг ба харьцуулдаг
- эд зүйлсийг өгөгдсөн шалгуурын дагуу ангилах, бүлэглэх ба хуваарилах (шүрэн бөмбөлгүүдийг өнгө, хэлбэр, хэмжээгээр нь салгаж ангилах)
- тунгааж бодно, энгийн үндэслэл гаргана, хийж буй зүйлийнхээ талаартайлбар өгнө ("ярьж бодох")
- энгийн харилцаа, нөхцөл байдлыг ойлгодог, энгийн асуудал, нөхцөл байдлыг шийддэг, үгэн жишээ, даалгавар, оньсого таавар, няцаалт, лабиринт зэргийг шийдэж чаддаг.
- орон зай-цаг хугацааны (жишээ нь: дээшээ, доошоо, доор, дээр, дотор ба гадна, өмнө, хожим, өчигдөр, өнөөдөр) ба хэмжээ, жинг илэрхийлсэн ойлголтуудыг (жишээлбэл, урт, богино, жижиг, том, хүнд, хөнгөн) ойлгодог.

## **7. Хүүхэд хангалттай хөгжсөн зорилготой анхаарал, санаж тогтоох, ухамсартайгаар суралцах чадвартай байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- үйл ажиллагаанд зохих хугацаагаар (10-15 минут орчим) анхаарлаа төвлөрүүлдэг
- өөрийг нь зориуд суралцах ажилд элсүүлэхийг "зөвшөөрдөг" (өөрт нь яг тэр мөчид сонирхолгүй байгаа үйл ажиллагаанд ч анхаарлаа төвлөрүүлж чаддаг)
- туулсан, үзсэн, сонссон зүйлээ зориудаар санаж, боломжийн хугацааны дараа эргэн санах, дахин гаргах, тодорхой хэмжээгээр дүгнэх чаддаг
- хурдан хэллэг, шүлэг, дууг санаж тогтоодог
- даалгавар, үүргээ хүлээн зөвшөөрдөг, даалгасан ажилдаа анхаарлаа төвлөрүүлж, бусад зүйл рүү анхаарахгүй хүчин чармайлт гаргаж, дуусгаж чаддаг
- зааврыг дагаж мөрддөг

- бие даан ажилладаг.

## **8. Хүүхэд нийгмийн хувьд бие даасан байх бөгөөд нийгмийн мэдрэмжтэй, үе тэнгийнхэнтэйгээ хамт амьдрах чадвартай байна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- нийгмийн үндсэн дүрмийг хэрэгжүүлдэг (мэндлэх, асуух, баярлах, уучлалт гуйх)
- хүүхэд, насанд хүрэгсэдтэй харилцаа холбоо тогтоож, тэдэнтэй ямар ч асуудалгүй харьцдаг, таалагдсан хүүхдүүдтэй найзалдаг
- ойр дотныхоо хүмүүсээс тодорхой хугацаанд салангад байхаас айдаггүй
- тоглоом хамтрагч (тоглоомд хамтрагч хайх, тоглохын тулд санал нийлэх, тоглоомын төлөө дүрээ өөрчлөх ба ээлжилж солигдож тоглох) байна
- хэсэг бүлгийн ажилд оролцдог, хамтарсан үйл ажиллагаанд хамтран ажилладаг, хэсэг бүлгийн санал ба шийдвэрт дасан зохицдог
- зөвшилцөж тохиролцдог, үзэл бодлоо хамгаалдаг
- хэсэг бүлэг (гэр бүл) дотор өгсөн, ойлгосон дүрмийг дагаж мөрддөг, зааварчилгаа өгсөн бол түүнийг дагаж мөрдөхөө ойлгодог.
- бусад хүүхдүүдтэй найрсаг, мэдрэмжтэй, халамжтай харьцдаг (тоглоом, хэрэгсэл, харилцан хэрэглэх, чихэрнээсээ өгөх, үүрэг даалгавар хийхэд туслалцах, бусдын юу хүсч байгааг анзаарах)
- бусдад анхаарал тавих чадвартай (хэлэлцэж тохиролцох, хүлээх, ээлжилж солигдох, дүү хүүхдүүдэд туслах) байдаг.

## **9. Хүүхэд соёлын санаачлагыг мэдэрч, бүтээлч байдлыг харуулна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- уран зохиол, кино, жүжиг, хөгжмийн тоглолтыг анхааралтай сонсох юмуу сонирхон үзэх
- зураг, хүүхэлдэй, гэрэл зургийн үзэсгэлэн, амьтны хүрээлэн эсвэл ботаникийн цэцэрлэгт зочлох, ферм, хөдөө гэх мэтийг сонирхдог байх
- хүүхдийн соёлын хөтөлбөр, үзвэр үйлчилгээ, баяр наадам, спортын арга хэмжээнд оролцох боломжтой байх
- өөрийн үзсэн харсныг тайлбарлаж хэлэх, үзсэн, сонссон зүйлээ ярьж хэлэх, сонирхолтой юу байсан, сонирхлыг нь татсан зүйл, юу зөв болон бүрүү байсан зэргийг хэлж чаддаг.
- ном сонирхдог, олон үлгэр ба түүх мэддэг, дуртай баатруудтай
- хэд хэдэн дуу, шүлэг, хурдан хэллэг мэддэг
- энгийн дуу дуулж, хэмнэлийг ялгаж, дагах (жишээ нь алга ташилт, бөмбөр дээр)
- урлах, загвар гаргах, зурах, будах, хайчлах, наах, сугалж таслах, угсрах, бүтээдэг
- дүр бүтээх, дүрд тоглох (жишээ нь сургууль, гэр бүлийн тухай, аялалын тухай, эмч болж тоглох), богино хэмжээний театрын дүрд тоглодог.

## **10. Хүүхэд өөрийн орчин, хүрээлэн буй ертөнц, практик амьдралд өөрийгөө чиглүүлж авч явна**

Хэрэв хүүхэд дараахи шаардлагыг хангаж байгаа бол:

- орчноо мэддэг (гэртээ, сургууль дээрээ), ойр эргэн тойрондоо найдвартай явж чаддаг (хаана амьдардаг, хаана цэцэрлэгт явдаг, дэлгүүр, тоглоомын талбай хаана байдаг, яаралтай үед хаашаа хандах г. м.)
- байнга тулгардаг нийтлэг практик үйл ажиллагаа, нөхцөл байдлыг зохицуулдаг (жишээ нь, бага зэргийн хэлүүлсэн зүйлийг дамжуулж хүргэх, дэлгүүрт юм худалдаж авах, төлбөрийг нь хийх, хэрэгтэй зүйлээ хэлэх, ойлгохгүй байгаа зүйлсийнхээ талаар асуух, утсаар ярих, эмх цэгц, цэвэр байхад анхаараг, өөртөө бие дааж үйлчилдэг, цэвэрлэгээний жижиг ажлыг хийдэг, ургамал болон жижиг тэжээвэр амьтдыг арчлах чадвартай)
- биеэ хэрхэн авч явахыг мэддэг (жишээ нь: гэртээ, цэцэрлэгт, олон нийтийн газар, эмч дээр, театрт, дэлгүүрт, явган хүний замд, гудамжинд, танихгүй ба гадны хүмүүстэй уулзах үед) түүнийг дагаж мөрдөхийг хичээдэг.
- өөрийн практик түршлагын хэмжээнд амьд ба амьгүй байгаль, хүмүүс, соёл, техникийн талаар мэдлэгтэй (жишээ нь, биеийн бүтцийн талаар, зарим эд эрхтэн ба хэсгийг нэрлэх, хүйсийг ялгах, гэр бүлийн гишүүд хэн болох, тэд юу хийдгийг мэддэг, төрөл бүрийн мэргэжил, туслах хэрэгсэл, багаж хэрэгслийг ялгаж чаддаг, мөнгө юунд зориулагдсан болохыг мэддэг, зарим ургамал, мод, амьтан болон бусад амьд бодгалийн нэрийг мэддэг, тээврийн хэрэгслээр зорчиход баримжаатай, зарим техникийн төхөөрөмж мэддэг), шууд тулгардаг нийтлэг нөхцөл байдал, үйл явдал, үзэгдлийг (жишээ нь: цаг агаар ба түүний өөрчлөлт, улирлын өөрчлөлт, бодис ба тэдгээрийн шинж чанар, аялал, хүрээлэн буй орчин, түүнийг хамгаалах, хог хаягдлын менежмент гэх мэт) ойлгодог.
- хэрэгцээтэй хүмүүс, зүйлсийг асарч арчлахад зохих ёсоор оролцдог
- хүрээлэн буй орчны тухай, тухайлбал, манай орны тухай (хот, уулс, гол мөрөн, хэл, соёл), бусад улс орон, үндэстнүүд байдаг тухай мэддэг, ертөнцийн олон янз байдал (тив, дэлхий, сансар огторгуйн тухай) ба дэг журмын талаар санамсаргүй, салангад мэдлэгтэй байх.
- сургууль, гэр, олон нийтийн газар (гудамж, тоглоомын талбай, дэлгүүр, эмчид очиход) зөв зохих хэмжээнд биеэ авч явах, аюулгүй байдлыг хангах, болзошгүй аюулыг (аюултай нөхцөл байдлыг үнэлдэг, болгоомжтой байх, эрсдэлд орохгүй байх) мэддэг, гудамжинд (зам гарахдаа анхаарлаа хандуулдаг, гэрлэн дохиог ойлгодог) биеэ авч явах үндсэн дүрмийг мэддэг, дагаж мөрддөг
- эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг мэддэг (тамхи татах)
- дээрэлхэх, хүчирхийлэл гэх мэт эрсдэлтэй, зохисгүй зан үйлийг мэддэг.